


Miami₃₂

Дэлгэцээр удирдах кассын систем



09/07

KasSys Kassen- und Datensysteme
Schulenburg Landstrasse 128

D-30165 Hannover

Telefon +49-511-67 66 943-0
Telefax +49-511-67 66 943-50

Email info@kassys.de

Internet <http://www.miami-kassen.de>

09/2007

Ерөнхий зүйл

Орчин үеийн кассын систем нь хурдан сурахад хялбар, найдвартай ажиллагаатай байх хэрэгтэй. Нөгөө талаар хурц өрсөлдөөн болон зээл олгоход банкуудаас тавьж буй өндөржүүлсэн шаардлагуудын улмаас тухайн аж ахуйн нэгжийн бизнесийн талаар ямагт оновчтой мэдээлэл өгөх шаардлагатай байна.

Miami нь германы зах зээлд санал болгож буй дэлгэцээр удирдах кассын системүүдийн анхдагчдын нэг. Аль 1994 онд түүнийг нэгэн яармагт танилцуулсан, эдүгээ олон тооны хэрэглэгчдийн талархал хүлээсэн бөгөөд уг систем нь дэлгэцээр удирдах системийн жишиг болсон билээ.

Нэн энгийн ажиллагаа, функцуудийн бүрэн хамаарал болон найдвартай ажиллагааны өндөр түвшингээр нь Miami системийг янз бүрийн орчинд: дангаараа ашигласнаас эхлээд томоохон сүлжээнд хүртэл хэрэглэж байна.



Miami auf Panasonic JS930-WS Kassensystem

Miami- системийн сүүлийн хувилбар:

Miami 32

32-битын хувилбарыг цаашид нийлүүлж буй болон ашиглагдаж буй 16-биттэй

харьцуулвал түүний үйлчилгээ нь улам хялбар болж, статистикийн талбар улам уян хатан болон олон тооны нэмэлт функцтэй болсон учир аж ахуйн газрын тухайн салбарт илүү боломжтой болсон юм.

Miami 32 нь олон хэлтэй. Эдүгээ дэлгэцийн хувилбар нь герман, англи болон франц хэл дээр байна. Нэмэлт хэлний хувилбаруудыг нэмж оруулах боломж байгаа. Мөн хэлийг өөрчлөх боломжтой. Нэг кассыг герман хэл дээр тохируулаад, нөгөө кассыг англи хэл дээр тохируулах юмуу герман хэлтэй зөөгч нь касстай германаар ажиллахад, түүний англи хэлт хамтран ажиллагч нь англи хэлээр ажиллаж болно. Тэрчлэн захиалгыг өөр хэлээр хэвлэж болох юм. Жишээлбэл гал зууханд ажиллаж буй олон үндэстний хамт олонд тохируулах.

Үйлчилгээний ажилтан

Нэн ялангуяа ажилтан нар түргэн солигдож буй цагт касстай хурдан ажиллаж сурах боломжийг шинэ ажилтан нарт олговол зохино. Сургах цагийг аль болох богино, гарч болох алдааг аль болох гаргахгүй, эс тэгвэл дурын цагт хийсэн алдааг олж мэдэх боломжтой байх.

Эдгээр шаардлагыг *Miami* дэлгэцээр удирдах систем оновчтой хангаж байна. Дэлгэцэнд зөвхөн тухайн үед хэрэглэгчид хамааралтай функцууд гарч байна.

Miami эхний хувилбараасаа эхлээд л бараа бүтээгдэхүүний код цээжлэх шаардлагагүй, код өөрчлөгдсөн тухай бүрт тохируулга хийх шаардлагагүй байжээ. Бүтээгдэхүүний нэрийг дэлгэцэнд шууд гаргаж байна. Нийтийн хоолны хувилбарт ширээнүүдийг дээрээсээ дүрслэн харуулж байгаа болохоор энд алдаа мадаг гарах боломжгүй байна.

Miami 32 нь энэ талаар улам боловсронгуй болжээ. Хэдийгээр маш олон функцтай ч дэлгэцийн байршилтыг ой тойд илүү орохоор болгосон. Тусгай бүх функцийг хяналтын болон тэмдэглэлийн функцууд ямагт хянаж байна.

09/2007

Шууд товчлуураар дуудах бүтээгдэхүүний нэр төрөл нь хязгааргүй. Маск бүрт 30-аас 63 хүртэл товчлуур байна. Нэг товчлуур нь бүтээгдэхүүнээ шууд буюу өөр маскаар дамжуулан дуудаж болно. Эдгээр маскыг хэр гүн дарааллаар цувруулах нь зөвхөн таны бүтээгдэхүүний нэр төрөл болон таны аж ахуйн газраас шалтгаална. Товчлуур бүрээр нэг үндсэн маск болон нэг дараалсан маск дуудахад товчлуурын хоёр даралтаар нь та 3000 илүү нэрийн бүтээгдэхүүн дуудаж болно. Гурван товчлуураар 10000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн хамааруулж болох юм. Та бүтээгдэхүүнээ кодоор буюу нэрээр нь сонгож болно.

Дээр нь 14 товчлуураар бүтээгдэхүүний 14 хуудсыг шууд дуудаж болох юм. Үүгээр та хэзээ ч бүтээгдэхүүний гол хуудсанд түргэн болон шууд хүрэх боломжтой байна.



Бүтээгдэхүүн бүрт 60 хүртэл нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой. Жишээлбэл хачирыг өөрчлөх буюу бүтээгдэхүүний хувилбар.

Бүтээгдэхүүний товчлуур нь бичгээр эсвэл , зургаар буюу бичиг болон зурагтай байж болно.

Худалдсан /захиалсан/ бүтээгдэхүүнийг дэлгэрэнгүй жасгаалтаар тод харуулна. Захиалсан бүтээгдэхүүнийг амархан цуцалж болно. Нэн даруй цуцлах буюу цуцлах эрхтэй нь дараа нь цуцлалт хийж болно. Үнийн өөрчлөлт, хөнгөлөлт /тухайн хөнгөлөлтөнд хамаарагдсан бүлэг, бүтээгдэхүүн буюу шууд хөнгөлт зэргээр/-

ийг хялбар болон түргэн оруулах боломжтой.


Тусгай функцид хязгаарлалт тогтоох боломж танд байна. Таны ажилтан бүр ямар эрхтэй байхыг та өөрөө тогтоож болно.

Ширээний захиалга

Ресторан зоогийн газар ширээний урьдчилсан захиалга нь ач холбогдол ихтэй хүчин зүйл юм

Miami 32 нь урьдын хувилбартай адил ширээнүүдийг дүрсэлж байна. Үүгээр ширээг андуурах болон захиалгыг будлиулах явдал барагтай гарахгүй.

Miami 32 –д дугуй, дөрвөлжин болон ташуу ширээ дүрслэх, өрөөний зураглал зэрэг баримжаа олоход тустай мэдээлэл оруулах боломжтой. Иймээс зүг чиг олох нь маш хялбар байна.



Зочдын захиалгыг авахад буюу захиалагдсан зүйлсийг хянахад ердөө холбогдох ширээний дүрсэнд хүрэхэд хангалттай байна.

Зочинтой буюу зочин нь захиалга өгсөн ширээнүүд шар өнгөтэй байна. Тохируулж болох тодорхой хугацаанд ширээнээс захиалга орж ирээгүй бол шар өнгө нь улаан болон хувирч, энэ ширээг анхааралдаа авахыг зөөгчид дохио өгнө. Мөн сүүлийн захиалганаас хойш өнгөрч буй цагийг гаргаж болно. Үүнээс зөөгч нь ширээгээ эргээгүй хэр удаж байгаагаа хянах боломжтой.

09/2007

Ширээ бүрт 99 хүртэл захиалгыг нэгэн зэрэг оруулж болох бөгөөд нэг даралтаар түүнийг дуудан үзэж болно.

Захиалгыг хялбар өөрчилж болох бөгөөд түүнийг нэгэн зэрэг салгаж болно.

Захиалга нь нэр төрлөөр нь гал зууханд, бааранд болон хүйтэн зууш гэх мэт бараа бүтээгдэхүүнд хамааруулан тааруулсан принтерт шууд хэвлэгдэнэ. Нэг кассанд 12 принтер тохируулах боломжтой.

Ширээнүүдийг хэсэг хэсгээр нь юм уу өрөөгөөр нь тусгаарлаж болно. Хэсгийн тоо хязгааргүй ба харин хэсэг тус бүрт 120 хүртэл ширээ оруулж болно.

Өрөө буюу хэсэг бүрт 5 өөр байрлалаар ширээнүүдийг байрлуулан хадгалж болох ба жишээ нь баяр ёслолын байрлал, энгийн байрлал, хурал семинар гэх мэтээр хадгалаад үүнийгээ хурдан хялбар солиж болно.

Тооцоо

Тооцоог кассын тасалбар, нэхэмжлэх болон тасалбарыг хэвлэхгүйгээр гээд 3 төрлөөр тохируулах боломжтой.

Мэдээж үүнд өөр өөр принтерийг зааж өгч болно.

Принтер бүрт текст буюу график 2 горим сонгох боломжтой. Кассын тасалбар хэвлэдэг ердийн принтерүүд зөвхөн тэмдэгт хэвлэхэд зориулалттай юм. Эдгээр нь текстийг маш хурдан хэвлэнэ. Харин график хэвлэх принтерүүд илүү үзэмжтэй хэвлэл гаргана. Тэдгээрт компанийн нэр, таних тэмдэг оруулан хэвлэх боломжтой юм.

Та кассын тасалбарыг текстийн түргэн хэвлэлээр нь, харин нэхэмжлэхийг график принтерээр тус тус хэвлэж болно. Үүгээр танай нэхэмжлэхүүд нэг ёсны танай компанийн таних тэмдэг бүхий нэрийн хуудас болно.

Нэхэмжлэх дээр үйлчлүүлэгчийн нэр хаягийг оруулах боломжтой. Мөн тодорхой дүнгээс шалтгаалан автоматаар нэр хаяг асуухаар ч тохируулж болно. (Германд татварын албанд 100 Еврогоос дээш үнийн дүнтэй нэхэмжлэхийг зөвхөн нэр хаягтайгаар л хүлээж авдаг).

Мөн кассын тасалбар, нэхэмжлэхийг шууд 2 хувь хэвлэгдэхээр эсвэл тодорхой дүнгээс дээш автоматаар 2 хувь хэвлэгдэхээр тохируулж болно.

Miami 32 нь төлөх дүнг хариулт мөнгөтэй нь гаргах боломжтой. Мөн төлөх дүнг авсан дэвсгэртээр нь ч оруулан хариулт мөнгөө бодуулж болно.

Эрх бүхий хүмүүс хэвлэгдсэн нэхэмжлэхийг дахин дуудаж болно. Мөн уул нэхэмжлэхийг түр түдгэлзүүлж, дараа нь дахин өөрчлөх боломжтой байна. Нэгэн үйлчлүүлэгч мөнгөө төлөх болсны дараа нэмэлт захиалга өгч, мөнгөө нэг мөсөн төлөхөөр шийдсэн байж болох юм.

Арын алба

Орчин үеийн оффисд кассын системд тавих шаардлага өндөр байна.

Үндсэн мэдээлэлүүд болон өдөр болгон солигдох бараа бүтээгдэхүүнийг маш хурдан болон амархан оруулах, банк буюу хөрөнгө оруулагчийн зүгээс нэмэгдэж буй шаардлагаар дүгнэлт хийж болох статистикийн мэдээллүүд, мөн шударга бус ажилтнуудаас шалтгаалан хяналтын тусгай механизмуудыг шаардаж байна.

Эдгээр шийдлүүдийг *Miami 32* боломжтой болгоно.

Шинэ бүтээгдэхүүнийг хэдхэн хоромд оруулж, сүлжээнд холбогдсон бүх касс тэдгээр зэрэг орно. Хүснэгт, бүдүүвч, зураглалыг дуудан өөрчлөж болно. Жишээлбэл та томоохон банкет хийхэд ширээнүүдийн байршилтыг өөрчлөх тохиолдолд. Шинэ хэрэглэгчийг хялбархан нэмж болно. Тэрбээр "9-дүгээр хэрэглэгч" мэт бус өөрийнхөө нэрийн дор ажиллаж

09/2007

байгаа болохоор түүнийг хянах боломж ч мэдээж илүү байна.

Өргөн хүрээтэй тохируулгаар танай системийг хэрэгцээнд чинь яг таг тааруулж болно.

Кассанд бараг бүх функцийг есөн шат дамжлагаар тухайн функцийг гүйцэтгэх эрх бүхий хүмүүст эрх олгох боломжтой.

Дүн шинжилгээ

Бүртгэсэн мэдээлэлд төрөл бүрийн дүн шинжилгээ хийх боломжтой.

Статистикийн хувьд та дэлгэцэндээ шууд гарах болон дуудаж гаргуулах мэдээллийг тогтоох боломжтой байна.

Энд олон янзын хослол байж болно. Та тухайлбал огноо, хэрэглэгч болон бүтээгдэхүүн сонгож болно. Нэхэмжлэхийг цуцалсан буюу өөрчлөсөн эсэхийг та шалгаж болно.

Нэг зөөгч хэдэн удаа үйлчилж нөгөө зөөгч хэдэн удаа тооцоо хийснийг та үзэж болно.

Тийнхүү бараг хязгааргүй боломжуудаар *Miami 32* танд бизнесийнх тань талаархи тоймыг харуулж байна.

Panasonic JS-930 2,0 GHz бүхий маш өндөр хурдтай Celeron процессортой байна. Түүний 15 inch дэлгэц нь хурц гэрэлтэй бөгөөд ямар ч нөхцөлд сайн уншигдана.

Түүний чимээ багатай сэнсийг онцолж тэмдэглүүштэй байна. Агаарын хоолойнууд нь тос болон тоосонцорыг оруулахгүй байна. Энэ нь уул системийн удаан хугацааны үйл ажиллагааг хангаж байна.

Hardware



Ердийн тохиолдолд *Miami 32*-ыг Panasonic JS930-WS буюу Panasonic JS935-WS кассуудтай нийлүүлж байна.

09/2007

Miami 32-ын үзүүлэлтүүд	✓= стандарт O= нэмэлт сонголт V= хийгдэж байгаа
Хүрч удирдах дэлгэц бүхий, онц хялбар хяналттай кассын систем	✓
Бүтээгдэхүүний хязгааргүй тоо	✓
Тус бүр 30-аас 63 товчлууртай бүтээгдэхүүний маск, тэрчлэн бүтээгдэхүүний үндсэн 14 төрлийн товчлууртай	✓
Бараа бүтээгдэхүүнийг дугаар, баркод болон үсгээр хайх	✓
тус бүр 120 ширээтэй хэдэн ч өрөөтэй	✓
Өрөөнүүдийг зургаар буюу планаар дүрслэх боломжтой	✓
Шууд цуцлах боломжтой, хүсвэл үүнийг хянах	✓
Дараа цуцлах (эрхээр хамгаалагдсан). Цуцалсан шалтгааныг бэлэн текстээр эсвэл дурын текстээр тэмдэглэх	✓
Хэрэглэгчийн бүртгэлийг дэлгэцээр, соронзон картаар, Dallas-түлхүүрээр, Addimat-түлхүүрээр эсвэл Ordercard-Transponder уншигчаар	✓
Хөнгөлөлтөнд хамаарагдсан бүтээгдэхүүнд хөнгөлтийг автоматаар бодно	✓
Хөнгөлтийг хувиар тооцолно, түүнийг зүйл бүр дээр буюу үнийн дүнгээс тооцоолох боломжтой	✓
Үнэ өөрчлөх, хасах үнэ боломжтой	✓
Үйлчлүүлэгчийн хаягийг тусгах боломжтой	✓
Бүтээгдэхүүний товчлуурыг түргэн оруулах боломж	✓
Бүтээгдэхүүнүүдийн товчлууруудын өнгийг, үсгийн өнгийг тус туст нэг бүрчлэн тохируулж болно	✓
Нийлбэр болон завсрын дүнг гаргах боломж	✓
Бүтээгдэхүүний товчлуурт шууд хүрэх боломж: бүтээгдэхүүний код буюу цагаан толгойгоор жагсаасан түүний нэрийг оруулах замаар	✓
НӨАТ-ыг тав хүртэл өөр түвшингээр тооцох боломж	✓
Бүтээгдэхүүний нэг товчлуур тутам 60 хүртэл хувилбар тусгах боломж	✓
Бүтээгдэхүүнийг товчлуураар буюу өөр аргаар хайх боломж	✓
Өрөө бүрийн ширээнүүдийг өөрчлөх боломж	✓
Зөөгч бүрийн дэлгэцийн нарийвчлалыг программаар автоматаар тохируулах боломж	✓
Принтерүүд, зөөгчдийн дэлгэц/касс кассын driver, сканерүүд болон соронзон туузны уншигчийн OPOS программ хангамж	✓
Систем бүрт захиалгын 12 хүртэл принтер, кассын тасалбар ба нэхэмжлэлийн хоёр принтер болон тайлангийн 1 принтер байж болох	✓

09/2007

/герман/англи/франц/ зэрэг олон хэлт систем, системийн түвшинд, кассын түвшинд болон хэрэглэгчийн түвшинд	✓
Илүү хэл	Бэлтгэлд
Зөөгчийн ажлын байранд захиалга, кассын тасалбар болон нэхэмжлэхийг текст буюу график принтерээр хэвлэх боломж	✓
Системд орох эрх мэдлийг 9 түвшингээр тогтоох боломж	✓
Үндсэн үзүүлэлтүүдийг шуурхай болон хялбар тохируулах боломж	✓
Системийн тохируулга өргөн боломж	✓
Нэхэмжлэхийн толгой болон доод мөрийг тус тус нь тохируулах боломж	✓
Ямар ч тооны үзүүлэлтүүдийг тодорхой хугацаанд үнэлэх/дүгнэх боломж	✓
Ширээний захиалга	○
Бүх бүтээгдэхүүний хэрэглэгээг сараар дүгнэж харуулах	✓
Агуулахын үлдэгдлийн хөтлөлт	○
Жор/сэлбэгийн жагсаалт	○
Үйлчлүүлэгчидтэй хийх тооцооны хөтлөлт: зээлийн лимит болон тухайн дансны үлдэгдлийн тооцоотой	○
Охин компаниудтай 9 хүртэл түвшинд тооцооны хөтлөлт	○
Ордерман ДОН хэмээх хөдөлгөөнт радио бэлэн мөнгөний тооцооны системийг нийлүүлэх боломжтой	○